# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 9 (486)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *"Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч" шагнал олгох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2007 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2007 оны гуравдугаар сарын 1 №9 (486)

## Гарчиг


### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | | |
|---|---|---|---|
| 141. | Авлигын эсрэг хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай | | 201 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 142. | Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам батлах тухай | Дугаар 09 | 202 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 143. | Хөтөлбөр батлах тухай | Дугаар 06 | 209 |
| 144. | Төлөвлөгөө батлах тухай | Дугаар 17 | 213 |
| 145. | Ажилд томилох тухай | Дугаар 21 | 230 |
| 146. | Ажилд томилох тухай | Дугаар 22 | 230 |
| 147. | Улсын сайн малчин шалгаруулах тухай | Дугаар 26 | 230 |
| 148. | Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын Засгийн газарт өгсөн чиглэлийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 27 | 230 |
| 149. | "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч" шагнал олгох тухай | Дугаар 29 | 231 |
| 150. | Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай | Дугаар 34 | 232 |


## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2007 оны 02 дугаар сарын 06-ны өдөр**

**Улаанбаатар хот**

### АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Авлигын эсрэг хуулийн 10.4, 14.1-д заасан хугацааг 2007 оны хувьд доор дурдсанаар мөрдсугэй:

1/хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах хугацааг 6 дугаар сарын 15-ны дотор;

2/хөрөнгө, орлогын мэдүүлэг хэвлэн нийтлэх хугацааг 3 дугаар улиралд.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр | Дугаар 09 | Улаанбаатар хот

### Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам батлах тухай

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт"-ыг 1 дүгээр, "Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах журам"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

*Монгол Улсын Их Хурлын 2007 оны 09 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт*

### Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт

........................................ -ны хөрөнгө, орлогын мэдүүлэг

#### Нэг. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал

| № | Асуулт | Эцэг/эх/-ийн болон өөрийн нэр | Төрсөн он, сар, өдөр | Эрхэлж байгаа ажил | Ажиллаж, сурч байгаа байгууллага, сургуулийн нэр, хаяг |
|---|---|---|---|---|---|
| 1. | Мэдүүлэг гаргагч | | | | |
| 2. | Эхнэр/ нөхөр/ | | | | |
| 3. | Хүүхэд | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| 4. | эцэг, эх | | | | |
| | | | | | |

Тайлбар: Хамт амьдарч байгаа хүүхэд, эцэг, эхийг бичнэ.

## Хоёр. Орлого

/төгрөгөөр/

| № | Орлогын нэр | Урьд мэдүүлсэн | | Тайлангийн үед орсон өөрчлөлт | | Одоо байгаа | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | өөрийн | гэр бүлийн гишүүдийн | өөрийн | гэр бүлийн гишүүдийн | өөрийн | гэр бүлийн гишүүдийн |
| 1. | Үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс | | | | | | |
| 2. | Шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | | | | | | |
| 3. | Үйл ажиллагааны орлого | | | | | | |
| 4. | Хөрөнгийн орлого | | | | | | |
| 5. | Хөрөнгө борлуулсны орлого | | | | | | |
| 6. | Бусад орлого | | | | | | |

Тайлбар: Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсны орлого, бусад орлого гэдгийг 2006 онд батлагдсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11, 12, 13, 14, 15, 21, 22 дугаар зүйлд зааснаар ойлгоно.

Гурав. Хөрөнгө, зээл, бэлэг

А. Барилга байгууламж

| № | Барилга, байгууламжийн төрөл | Байршил | Үнийн дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |

Б. Авто тээврийн хэрэгсэл

| № | Төрөл, марк | Тоо хэмжээ | Үнийн дүн | Бүртгэлийн дугаар | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1. | | | | | |
| 2. | | | | | |
| 3. | | | | | |

В. Мал

| № | Төрөл | Тоо, толгой | Үнийн дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |

### Г. Газар

| № | Газар өмчлөх эрхийн бичгийн дугаар | Байршил /бүс нутаг/ | Худалдаж авсан огноо | Үнийн дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1. | | | | | |
| 2. | | | | | |

### Д.Хадгаламж

| № | Банк, санхүүгийн байгууллагын нэр | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|
| 1. | | | |
| 2. | | | |
| 3. | | | |

### Е. Эрх, концесс, лиценз

| № | Төрөл | Эзэмшигчийн нэр | Орлого | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |

### Ж. Хөрөнгө оруулалт, хувьцаа

| № | Хөрөнгө оруулалтын төрөл | Хувьцааны сери, гэрээний дугаар | Хувьцаа гаргасан компани | Хувьцааны тоо | Хувьцааны дүн | Худалдаж авсан үнэ | Ногдол хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | | | | | | | | |
| 2. | | | | | | | | |
| 3. | | | | | | | | |
| 4. | | | | | | | | |
| 5. | | | | | | | | |

### З. Зээл

| № | Зээлдүүлэгчийн нэр хаяг, бизнесийн үйл ажиллагааны чиглэл | Зээлийн хэмжээ | Зээлийн хүү | Төлж дуусах хугацаа | Зээлийн барьцаа, батлан даагч | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | | | | | | |
| 2. | | | | | | |
| 3. | | | | | | |

### И. Бэлэг

| № | Эх сурвалжийн нэр, хаяг | Бизнесийн үйл ажиллагааны чиглэл | Авсан бэлгийн товч танилцуулга | Үнийн дүн | Авсан огноо | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | | | | | | |
| 2. | | | | | | |

Тайлбар: Тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас дээш хэмжээний үнэтэй бэлгийг бичнэ.

*Монгол Улсын Их Хурлын 2007 оны 09 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт*

## АЛБАН ТУШААЛТНЫ ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Авлигын эсрэг хуулийн 4.1-д заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ Авлигын эсрэг хуулийн 10.4-д заасан хугацаанд, батлагдсан маягтын дагуу үнэн зөв гаргаж Авлигын эсрэг хуулийн 11.1-д заасан байгууллага, албан тушаалтанд биечлэн болон энэ журмын 2.7, 2.9 -д заасны дагуу хүргүүлнэ.

1.3.Мэдүүлэг гаргагч мэдүүлгээ бүртгүүлсний дараа түүний хөрөнгө, орлогод их хэмжээний өөрчлөлт орсон бол Авлигын эсрэг хуулийн 10.5-д заасны дагуу 30 хоногийн дотор мэдэгдэж бүртгүүлнэ.

### Хоёр. Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах, түүнийг бүртгэх, хадгалах

2.1.Дараахь албан тушаалтан хөрөнгө, орлогын мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт гаргаж өгнө:

2.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч;

2.1.2.Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн;

2.1.3.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, дэд сайд;

2.1.4.Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний орлогч, гишүүн;

2.1.5.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга;

2.1.6.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч;

2.1.7.Монгол банкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч;

2.1.8.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;

2.1.9. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;

2.1.10.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;

2.1.11. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга;

2.1.12.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга;

2.1.13.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн;

2.1.14.Үндэсний статистикийн газрын дарга, дэд дарга;

2.1.15.Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн;

2.1.16.Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга;

2.1.17.Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн;

2.1.18.Ерөнхий аудитор, түүний орлогч;

2.1.19.Засгийн газрын агентлагийн дарга;

2.1.20. аймаг, нийслэлийн иргэдийн Хурлын дарга;

2.1.21.аймаг, нийслэлийн Засаг дарга, орлогч;

2.1.22.олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга болон Ерөнхий захирал.

2.2. Энэ журмын 2.1-д заасна ас бусад албан тушаалтан хөрөнгө, орлогын мэдүүлгээ дараахь байгууллага, албан тушаалтанд гаргаж өгнө:

2.2.1. энэ хэсгийн 2.1.5-д заасн аас бусад бүх шатны шүүхийн шүүгч, шүүхийн тамгын газар, хэлтсийн дарга нар Шүүхийн ерөнхий зөвлөлд;

2.2.2.Засгийн газраас томилогддог албан тушаалтан Төрийн албаны зөвлөлд;

2.2.3.төрийн захиргааны болон тусгай албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч өөрийг нь томилсон буюу удирддаг эрх бүхий албан тушаалтанд;

2.2.4. аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын төлөөлөгчид, Хурлын дарга, нарийн бичгийн дарга нар аймаг, нийслэлийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд;

2.2.5.сум, дүүрэг, баг хорооны Засаг дарга, орлогч нар аймаг, нийслэлийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд;

2.2.6.төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон тийм өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн захирал, тэдгээрийн төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж байгаа болон захиргааны албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчид Төрийн өмчийн хороонд;

2.2.7.орон нутгийн өмчит бол тийм өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн захирал тухайн Засаг даргын Тамгын газарт;

2.2.8.төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу түр, эсвэл байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан Засгийн газрын хэрэг эрхлэх газарт;

2.2.9. Төрийн албаны тухай хуулийн 6.1.14, 6.1.15-д заасан улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтан, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтан харьяалагдах төрийн байгууллагын Тамгын газарт.

2.3.Сонгуулийн ерөнхий хороо Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7.4.4-д заасны дагуу, тойргийн хороо Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 16.2.7-д заасны дагуу, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 12.1.6, 13.1.2-т заасны дагуу тус тус бүртгэж Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэн өгнө.

2.4.Бүх шатны сонгуулийн хороод сонгуулийн нэгдсэн дүн гарсны дараа тухайн шатны сонгуульд сонгогдогчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг сонгууль дууссанаас хойш 14 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт ирүүлэхдээ мэдүүлэг гаргагчийн нэрсийн жагсаалт, мэдүүлгийн эх хувийг "нууц" гэсэн тэмдэг дарж битүүмжилсэн дугтуйнд хийж ирүүлнэ.

2.5.Авлигын эсрэг хуулийн дагуу хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих ажлыг тухайн байгууллагын хуулийн асуудал эрхэлсэн алба, эсхүл аль нэг ажилтан нь хариуцан ажиллаж, Авлигын эсрэг хуулийн 6.1.8 дахь заалт, 11, 12 дугаар зүйлд заасан үүргийг хэрэгжүүлнэ.

2.6.Мэдүүлгийг засваргүй, товч тодорхой бичих бөгөөд асуулт болгонд хариулна.

2.7.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ шуудангаар илгээх бол эрх бүхий албан тушаалтны нэр дээр "гарт нь" гэж хаяглан баталгаат илгээмжээр ирүүлэх бөгөөд энэ тохиолдолд мэдүүлэг бичигдсэн хугацааг илгээмж дээрх шуудангийн тэмдэглэлийг үндэслэн тооцно.

2.8.Шуудангаар ирсэн мэдүүлгийг тухайн байгууллагын бичиг хэрэг хариуцсан ажилтан хүлээн авч, илгээмжийг задлалгүйгээр эрх бүхий албан тушаалтанд шууд хүлээлгэн өгнө.

2.9.Мэдүүлэг хүлээн авах эрх бүхий этгээд мэдүүлгийг хүлээн авсан тухай тусгай бүртгэл хөтөлнө.

2.10.Мэдүүлэг гаргагч электрон шуудангаар мэдүүлгээ илгээж болох бөгөөд хаяг, гарын үсгийн баталгаажилт, нууцлал зэргийг мэдүүлэг хүлээн авах эрх бүхий этгээдтэй урьдчилан тохиролцсон байна.

**Гурав. Хөрөнгө, орлогын мэдүүлэг бөглөх**

3.1.Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгт дараахь зүйлийг тусгана:

3.1.1.мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал;

3.1.2.орлого;

3.1.3.хөрөнгө, зээл, бэлэг.

3.2. Энэ журмын 3.1.1-д өөрийн болон хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүд /нөхөр буюу эхнэр, хүүхэд, эцэг, эх /-ийн нэр, төрсөн он, сар, өдөр, эрхэлж байгаа ажил, ажиллаж, сурч байгаа байгууллага, сургуулийн нэр, хаягийг бичнэ.

3.3. Энэ журмын 3.1.2-т заасан орлогод цалин, хөдөлмөрийн хөлс, мөнгөн шагнал, урамшуулал, хөдөлмөр эрхлэлтийн орлого, үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө

борлуулсны орлого, мал бүхий этгээдийн орлого, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагын тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого, урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, шууд бус орлогыг, хэрэв орлогыг эд зүйлийн хэлбэрээр авсан бол дүнг нь мөнгөн хэлбэрт шилжүүлж тус тус бичнэ.

3.4. Энэ журмын 3.1.3-т заасан орлогод албан тушаалтны өөрийн болон гэр бүлийн гишүүдийн үл хөдлөх, хөдлөх хөрөнгө, хадгаламж, хөрөнгө оруулалт, хувьцаа, үнэт цаас болон банк, бусад санхүүгийн байгууллага, иргэд, хуулийн этгээдээс авсан зээл, түүнчлэн тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас дээш хэмжээний үнэтэй бэлгийг бичнэ.

**Дөрөв. Бусад**

4.1.Авлигатай тэмцэх газарт ирүүлсэн хөрөнгө, орлогын мэдүүлгийг архивт хадгалах бөгөөд түүнийг хадгалах, ашиглах журмыг Авлигатай тэмцэх газрын дарга, архивын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай хамтран батална.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2007 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр** | **Дугаар 6** | **Улаанбаатар хот**

**Хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, явцын талаар жил бүрийн IY улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Сангийн сайд Н.Баяртсайханд үүрэг болгосугай.

3. "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолын 17 дугаар хавсралтад "46. Худалдан авах ажиллагааны хүний нөөцийг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөрийг удирдан зохицуулах зөвлөлийн тэргүүн-Сангийн сайд" гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**САНГИЙН САЙД Н.БАЯРТСАЙХАН**

***Засгийн газрын 2007 оны 06 дугаар тогтоолын хавсралт***

## ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа (цаашид "Засгийн газрын худалдан авах ажиллагаа" гэх) нь дотоодын нийт бүтээгдэхүүний 15-20 хувь, Засгийн газрын төсвийн зарцуулалтын 25-30 хувийг тус тус эзэлж байна.

Засгийн газрын худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт хариуцсан ажилтан, худалдан авах ажиллагааны чиглэлээр ажиллах шинэ боловсон хүчин, их, дээд сургуульд худалдан авах ажиллагааны чиглэлээрх сэдвийг заах багш, тухайн асуудлаар мэргэших оюутан, бусад мэргэжилтэнг мэргэшүүлэх, холбогдох хууль, жишиг бичиг баримтыг амьдралд зохистой хэрэгжүүлэх, ашиглах чадварыг эзэмшүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх байнгын тогтолцоо бий болгох шаардлага хурцаар тавигдаж байна.

Үүний тулд худалдан авах ажиллагааны чиглэлээр багшлах боловсон хүчний чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ сургалтын хөтөлбөрийг гүнзгийрүүлж, хамрах хүрээг тодорхойлон Засгийн газар, хувийн хэвшил болон нийтийг хамруулсан сургалтыг системтэй болгож, чадварлаг сургалтын байгууллага бий болоход дэмжлэг үзүүлэх, тэдгээрийг бодлого, арга зүйгээр зохицуулах зорилгоор үндэсний боловсон хүчин бэлтгэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх нь оновчтой гэж үзсэн болно.

Шинэчлэн батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

худалдан авах тухай хууль, түүнд нийцүүлэн гарсан журам, заавар нь Засгийн газрын худалдан авах ажиллагааны төвлөрсөн бус тогтолцоог бэхжүүлж, захиалагч байгууллагууд өөрийн худалдан авах ажиллагаагаа удирдан зохион байгуулах, оролцогч талуудын үйл ажиллагааг зохицуулах механизмыг боловсронгуй болгосны үндсэн дээр мэргэшсэн байдлыг дээшлүүлэхийг шаардаж байна.

Хуульд зааснаар худалдан авах ажиллагааны нэгдсэн бодлого, арга зүй, зохицуулалтыг хариуцах болон захиалагч байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хүлээсэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Сангийн яам өөрийн үндсэн бүтцэд худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтыг хариуцсан нэгж байгуулан ажиллаж байна.

Засгийн газар худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгон бэхжүүлэх ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулж уг тогтолцоог хөгжүүлэх шинэчлэлтийг засаглалыг сайжруулах зорилтын хүрээнд дэмжин ажиллаж байгаа юм.

**Хоёр. Удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн үйл ажиллагааг удирдан зохицуулах үүргийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл бүхий үндэсний зөвлөл гүйцэтгэнэ.

Үндэсний зөвлөл нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлэгч байгууллагад шаардлагатай бодлогын чиглэл өгч ажиллан, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд үнэлгээ дүгнэлт өгч, шаардлагатай арга хэмжээний талаархи саналыг Засгийн газарт танилцуулна.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч сонгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, худалдан авах ажиллагааны бодлого, арга зүй, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх өдөр тутмын ажлыг зохион байгуулна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин зохицуулж ажиллана.

**Гурав. Зорилго**

Засгийн газрын худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үр ашигтай хэрэгжүүлэх чадвар бүхий мэргэшлийн боловсон хүчний оролцоог хангах замаар татвар төлөгчдийн хөрөнгө ил тод, шударга өрсөлдөөнийг дэмжсэн хэлбэрээр зарцуулагдаж Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

**Дөрөв. Зорилтууд, хүрэх үр дүн**

Энэхүү хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн 2007-2010 онд Засгийн газрын худалдан авах ажиллагааны хүний нөөцийг хөгжүүлэхэд дараахь 5 зорилтыг дэвшүүлсэн бөгөөд хөтөлбөрт заасан арга хэмжээг амжилттай хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг тодорхойлов. Үүнд:

4.1. Зарим үндсэн мэргэжлийн суурь боловсрол эзэмших шатанд Засгийн газрын худалдан авах ажиллагааны анхан шатны мэдлэг олж авах боломжийг бүрдүүлнэ.

Үр дүн: 5-аас доошгүй их дээд сургуулийн үндсэн болон сонгон суралцах хичээлийн хөтөлбөрт худалдан авах ажиллагааны чиглэлийн хичээл орсон байна.

Хууль, худалдаа, эдийн засаг, санхүү, инженер, удирдлагын чиглэлээр их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн 20-иос доошгүй хувь нь худалдан авах ажиллагааны онол, эрх зүйн үндсийг үндсэн хичээлийн хүрээнд судалсан болно.

Бодлогын арга хэмжээний чиглэл: Их, дээд сургууль, коллежийн багш, профессор болон бусад сургалтын байгууллагын багш нарын дунд худалдан авах ажиллагааны сургагч-багш бэлтгэх тусгайлсан программ бий болгон хэрэгжүүлнэ.

Бэлтгэгдсэн сургагч-багш нарын бие даасан үйл ажиллагаа, санаачилгыг дэмжиж, худалдан авах ажиллагааны чиглэлээр хичээл заах, туршлага, мэдээлэл солилцох зорилгоор багш нарын хамтран ажиллах аливаа хэлбэрийг дэмжинэ.

Худалдан авах ажиллагааны талаархи сэдвийг сургалтын программд шинээр оруулж байгаа сургалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж хичээлийн багц, арга зүй боловсруулах, хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлнэ.

4.2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал хариуцсан төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид ажиллах ажилтныг мэргэшүүлэх, давтан сургах тогтолцоог бүрдүүлнэ.

Үр дүн: Худалдан авах ажиллагааны сургагч-багшийн тоог 100-д хүргэж, орон нутагт ажиллах сургагч багш нарын тоог нэмэгдүүлж, улсын хэмжээнд сургалтын үндэсний тогтолцоо ажиллах боломжийг бүрдүүлнэ.

Төсвийн менежер, нягтлан бодогч, санхүүч болон хөрөнгө оруулалт, төсөв, барилга, худалдаа

болон хуулийн мэргэжилтэн зэрэг худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал хариуцсан ажилтнуудын 60-аас доошгүй хувь нь худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх шаардлагыг хангасан байна.

Худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалт явуулж, олон улсын жишигт нийцсэн зөвлөгөө өгдөг төрийн бус байгууллага болон сургалтын байгууллага бий болсон байна.

Бодлогын арга хэмжээний чиглэл: Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал хариуцсан төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид ажиллах ажилтан нь энэ чиглэлээр мэргэшсэн байх шаардлагыг тусгасан журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төрийн албаны зөвлөлтэй хамтран боловсруулж мөрдүүлнэ.

Худалдан авах ажиллагааны талаархи мэдлэг олж авах, мэргэших хэрэгцээг хангаж чадах байнгын үйл ажиллагаатай сургалтын төв байгуулна. Төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн ажилтнуудыг сургалтад өргөнөөр хамруулна. Сургалтыг тогтмол зохион байгуулж шаардлагатай бол зардлыг нь төсвөөс санхүүжүүлнэ.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг дэмжих, олон нийтэд хүргэх, худалдан авах ажиллагааны тогтолцоог зөв хөгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэжилтэн, багш нарын хамтын ажиллагаа, мэдлэг, дадлага, туршлага солилцох боломжийг хангана. Мэргэжилтэн, багш нар үр ашигтай хамтран ажиллах боломжийг бүрдүүлнэ.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны чиглэлийн мэргэжлийн байгууллагатай хамтран төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийг худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтнаар хангах арга хэмжээ авна.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах зорилгоор хууль хяналтын байгууллагын ажилтнууд, ялангуяа санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчдын худалдан авах ажиллагааны талаархи мэдлэгийг нэмэгдүүлэхэд анхаарч, сургалтад хамруулна.

4.3. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид одоо ажиллаж байгаа хүмүүсийг худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Үр дүн: Төсвийн байгууллагын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд шууд оролцож байгаа ажилтнуудын 80-аас доошгүй хувийг энэ чиглэлээр давтан мэргэшүүлж худалдан авах ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулна.

Бодлогын арга хэмжээний чиглэл: Сангийн яам холбогдох бусад байгууллагатай хамтран худалдан авах ажиллагааны өнөөгийн тогтолцоог дэмжиж богино хугацааны сургалтын программ боловсруулж хэрэгжүүлнэ.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны чиглэлээр төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, хувийн хэвшил, төрийн бус байгууллагад зориулж тусгайлсан сургалтын хөтөлбөрүүд боловсруулж хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрт хамрагдах ажилтнуудын хэрэгцээ, шаардлага, зардлын эх үүсвэр, салбарын болон үйл ажиллагааны онцлогийг тусгасан үр ашигтай хэрэгжүүлэх арга хэлбэрийг тогтоож холбогдох байгууллагуудыг татан оролцуулна.

Засгийн газрын худалдан авах ажиллагаанд оролцож байгаа ажилтнуудын чадварын түвшинтэй уялдуулан хичээлийн багц, заавар, журмыг урьдчилан бэлтгэж, захиалагч нарт танилцуулж зөвшилцөнө.

Засгийн газар болон хандивлагч орнуудын санхүүжүүлж байгаа техник туслалцааны төслийн хүрээнд хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч байгууллагын чадавхийг сайжруулж энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлнэ.

4.4 Худалдан авах ажиллагааны чиглэлээр хичээл заах сургалтын байгууллагын сургалтын чанар, стандартыг баталгаажуулах зорилгоор Боловсролын тухай хуулийн 22.1.4-т заасан шинжээчийн хэсгийг төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага томилж боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран магадлан итгэмжлэх олгоно.

Үр дүн: Худалдан авах ажиллагааны чиглэлээр явуулах сургалтын чанарыг баталгаажуулж шаардлага хангасан 4-өөс доошгүй сургалтын байгууллагад магадлан итгэмжлэл олгоно.

Бодлогын арга хэмжээний чиглэл: Засгийн газрын худалдан авах ажиллагааны сургагч-багшид тавигдах шалгуур, шаардлагыг хангасан хүмүүст сертификат олгох журам боловсруулж мөрдөнө.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны чиглэлээр явуулах сургалтын түвшин, чанар, стандартыг тогтоож мөрдүүлнэ.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны сургалт зохион байгуулах, боловсрол, сургалтын байгууллагуудад тавигдах шаардлагыг гаргаж, тухайн чиглэлээр магадлан итгэмжилнэ.

4.5. Худалдан авах ажиллагааны бодлого, арга зүй, онол, практикийн талаархи мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлнэ.

Үр дүн: Олон нийтэд зөв ойлголт өгөх, мэдээллээр хангах Засгийн газрын худалдан авах ажиллагааны зарчим, үйл ажиллагаар тусгасан олон улсын жишигт нийцсэн цахим хуудсыг ажиллуулна.

Худалдан авах ажиллагааны үйл ажиллагааны хөгжлийг дэмждэг төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.

Бодлогын арга хэмжээний чиглэл: Засгийн газрын худалдан авах ажиллагааны талаархи дэлгэрэнгүй мэдээлэл авах, санал хүсэлтээ харилцан солилцох нээлттэй вэб хуудас ажиллуулна.

Худалдан авах ажиллагааны чиглэлээр ажиллаж байгаа багш, мэргэжилтэн, ажилтнууд нэгдэж худалдан авах ажиллагааны ойлголт, мэдлэгийг улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэхийг дэмжинэ.

Худалдан авах ажиллагааны талаар олон улсын байгууллага болон гадаад оронтой байгуулах хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээрийг холбогдох ажилтнууд болон олон нийтэд таниулах арга хэмжээг зохион байгуулна.

Худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, мэдээлэл авах боломжийг өргөжүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалт явуулахыг дэмжинэ.

**Тав. Зарчим, тавигдах шаардлага**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцож байгаа байгууллага, ажилтны үйл ажиллагаа дараахь зарчимд нийцсэн байна:

- Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, заавар, журамтай нийцсан байна.
- Олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байна.
- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд болох сонирхогч бүх талуудын хэрэгцээ шаардлагыг хангасан байна.
- Олон улсын түвшинд хүрсэн, оновчтой зохион байгуулалт, бүтэцтэй байна.
- Ил тод тайлагнагдаж байна.
- Хөтөлбөрийн үйл ажиллагааг тухай бүрт нь тодотгож, шаардлагатай бол өөрчлөлт оруулна.

Хөтөлбөрийн зорилт, түүнд хүрэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дараахь шаардлагыг хангасан байх нь түүнийг амжилттай хэрэгжүүлэх үндэс болно:

Худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнууд энэ чиглэлээр бүрэн мэргэшсэн байна.

Төрийн байгууллагад төсөвийн зарцуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалт, гэрээ, хэлэлцээрийн асуудал хариуцсан ажилтнуудыг худалдан авах ажиллагааны чиглэлээр бүрэн мэргэшүүлж сертификат олгоно. Шинээр авах боловсон хүчинд тавигдах шалгуурыг холбогдох ажлын байрны шаардлагад оруулна.

Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн хангалттай тооны сургагч-багш бэлтгэгдсэн байна.

Худалдан авах ажиллагааны сургалтын нэгдсэн хөтөлбөр, аргачлал боловсруулж сургалтад нэвтрүүлэх, багш нарын мэдлэг, чадварыг дээшлүүлж мэргэшүүлэх, сургагч-багш нарын тоог нэмэгдүүлнэ.

Бүх түвшинд худалдан авах ажиллагааны сургалтыг тасралтгүй зохион байгуулах "санхүүгийн болон шаардлагатай бусад нөөц"-тэй байна.

Худалдан авах ажиллагааны мэдлэг олж авах, мэргэших эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангах үйл ажиллагаа төсвөөс бүрэн санхүүжүүлэх боломжгүй тул төрийн албан хаагчид болон олон нийтэд худалдан авах ажиллагааны сургалт, мэргэжлийн зөвлөгөө өгөх үйл ажиллагааны зардлаа нөхөх ашгийн бус хэлбэрт шилжүүлэх шаардлагатай байна. Энэхүү шилжилтийн шатанд гадаадын техник туслалцааны төслийн хүрээнд санхүүгийн эх үүсвэрийг дайчлан ажиллах боломжийг хайх шаардлагатай байна.

Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн, судлаач, зөвлөх, хуульч, шинжээч зэрэг хангалттай тооны боловсон хүчин бэлтгэж нарийн мэргэшүүлэн олон нийтийн сэтгэл зүй, төсөөлөл ойлголтыг зөв төлөвшүүлнэ.

Хууль хяналтын байгууллагын ажилтнууд, сэтгүүлчид, олон нийтийн дунд тендер шалгаруулалттай холбоотой ойлголт, мэдлэг, туршлага хангалтгүй байгаа тул өнгөрсөн хугацаанд тодорхой хэмжээгээр хуримтлагдсан туршлагад суурилан худалдан авах ажиллагааг гүнзгий судлах, хууль тогтоомжийг зөв, зохистой хэрэгжүүлэх чадварыг хөгжүүлэх шаардлагатай

Иймд олон нийтэд зөв ойлголтыг хүргэх сургалт, сурталчилгаа, зөвлөгөөг өргөжүүлэх, хуулийг хэрэгжүүлсэн дадлага, туршлагыг хуваалцуулах, орон даяар түгээхэд Засгийн газрын бодлого, дэмжлэгийг чиглүүлэх шаардлагатай байна.

Худалдан авах ажиллагааг хөгжүүлэх хувь хүмүүсийн үйл ажиллагаа, хүсэл сонирхлыг нэгтгэн чиглүүлэгч төв байгууллагатай болно.

Худалдан авах ажиллагааны тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж нийгэмд үйлчлэх төрийн бус болон сургалтын байгууллагууд худалдан авах ажиллагааны сургалт, сурталчилгааг өргөжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулах тул төрийн бус байгууллагуудыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлогын хэрэгжилтэд татан оролцуулж, үр ашигтай хамтран ажиллана. Энэ чиглэлийн зарим ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхэд анхаарна. Ингэснээр олон нийт худалдан авах ажиллагааны талаар бүрэн зөв ойлголт авч, цаашид төсвийн хөрөнгийн зарцуулалт болон гэрээ, хэлцэл хийхдээ ухамсартайгаар зөв хяналт тавих чадвар нэмэгдэнэ.

**Зургаа. Санхүүжилт**

Засгийн газрын худалдан авах ажиллагааны хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр нь олон улсын банк, санхүүгийн байгууллага болон хандивлагч орнуудын техник туслалцаа, төсвийн болон хувийн хөрөнгө, төрийн бус байгууллага, хувь хүмүүсийн хандив зэргээс бүрдэнэ.

Засгийн газрын захиалгаар хийгдэх худалдан авах ажиллагааны сургалтыг энэ чиглэлээр ажиллах чадвар, туршлага бүхий мэргэшсэн сургалтын байгууллага, төрийн бус байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх чиглэл баримтална.

Цаашид худалдан авах ажиллагааны байнгын сургалтын программ бий болгож улсын хэмжээнд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх сургалт явуулах байгууллага нь үйл ажиллагааны зардлаа сургалт, үйлчилгээний төлбөрөөр нөхөх зарчмаар ажиллах болно.

**Долоо. Үр дүнг үнэлэх**

Төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын худалдан ава ажиллагааны бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан нэгж нь жил тутам энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хүрсэн үр дүнг үнэлж дүгнэн Үндэсний зөвлөлд тайлагнах бөгөөд Үндэсний зөвлөл нь хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдон гаргасан чиглэл, шаардлагатай бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Түүнчлэн хөтөлбөрийн жилийн эцсийн тайланг худалдан авах ажиллагааны вэб хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

Үндэсний зөвлөл нь 2009 оны эхний улиралд багтаан уг хөтөлбөрийн 2007-2008 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж тайланг Засгийн газарт танилцуулна. Эхний 2 жилд хүрсэн үр дүнг үнэлж, 2009-2010 онд энэхүү зорилт, үйл ажиллагааг тодотгон, шаардлагатай бол түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаарх саналыг уг тайланд тусгана.

Үндэсний зөвлөл нь 2011 оны эхний улиралд багтаан 2007-2010 оны хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайланг Засгийн газарт танилцуулна. Энэхүү бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтууд хэрхэн биелж ямар үр дүнд хүрсэн тухай үнэлгээ, дүгнэлтийг олон нийтэд мэдээлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2007 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр** | **Дугаар 17** | **Улаанбаатар хот**

**Төлөвлөгөө батлах тухай**

Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор батлсугай.

2. Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багц болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Сангийн сайд Н.Баяртсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД — **М.ЭНХБОЛД**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД — **Д.ОДБАЯР**

## МОНГОЛ УЛСАД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2007, 2008 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Зорилт | Хөтөлбөрийн заалт | Арга хэмжээ | Хэрэгжүүлэх Хугацаа | Гарах үр дүн | Зохион байгуулах байгууллага | Хамтран ажиллах байгууллага | Санхүүгийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хүний эрхийг хангах үндэсний механизмыг бэхжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр | | | | | |
| 1. | НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудаас гаргасан хүний эрхийн гэрээ, конвенцид нэгдэн орохыг дэмжих, тэдгээрийг соёрхон батлах, хэрэгжүүлэх, тайлагнах журмыг нарийвчлан тогтоож хэрэгжүүлэх арга хэмжээ авах | 1.1.1.3 | 1. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай Палермогийн конвенц болон түүний нэмэлт протоколууд, 2002 оны Эрүүдэн шүүх, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг хориглох конвенцийн нэмэлт протоколыг судалж, нэгдэн орох асуудалд санал боловсруулах; | 2007 оны Ш улиралд | Конвенц, Протокол нэгдэх эсэх асуудлыг шийдвэрлэсэн байна | ХЗДХЯ | ГХЯ,УИХ-ын Тамгын газар, Хууль зүйн үндэсний төв, "Эмнести интернэшнл", "Нээлттэй нийгэм форум" ТББ, Хүний эрхийн үндэсний комисс, "Хүний эрх, хөгжил төв" | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| | | | 2. Цагаач ажилчид ба тэдгээрийн гэр бүлийг хамгаалах тухай конвенцид нэгдэн орох талаар санал боловсруулах; | 2007 оны Ш улиралд | Конвенцид нэгдэх эсэх асуудлыг шийдвэрлэсэн байна | ГХЯ | ХЗДХЯ,УИХ-ын Тамгын газар, Хууль зүйн үндэсний төв, "Эмнести интернэшнл", Нээлттэй нийгэм форум" ТББ, Хүний эрхийн үндэсний комисс, "Хүний эрх, хөгжил төв" | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| | | | 3. НҮБ-ын Бие хүн, нийгмийн бүлэг болон байгууллагын эргээс бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалахад оролцох эрх, хариуцлагын тунхаглалыг дэмжих эсэх талаар санал боловсруулах; | 2007 оны IY улиралд | Тунхаглалыг дэмжих эсэх асуудлыг шийдвэрлэсэн байна | ГХЯ | ХЗДХЯ, УИХ-ын Тамгын газар,Хууль зүйн үндэсний төв, "Эмнести интернэшнл" ТББ | Олон улсын байгууллагын санхүүжилт |
| | | | 4. Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийн тайланг бэлтгэх журмын төслийг боловсруулах; | 2007 оны эхний хагас жилд | Олон улсын гэрээний хэрэгжилтийн талаархи тайлан илтгэл бичих журам тодорхой болно | ГХЯ | ХЗДХЯ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүйн үндэсний төв | Улсын төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 5. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилтийн талаарх үндэсний 5 дахь илтгэлийг бэлтгэх; | 2007 оны I улиралд | Үндэсний илтгэл НҮБ-д хэлэлцүүлэхээр хүргэгдсэн байна | ХЗДХЯ | ГХЯ, НХХЯ, Хууль зүйн үндэсний төв, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо | Улсын төсөв |
| | | | 6. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилтийн талаарх үндэсний ээлжит илтгэлийг бэлтгэх; | 2007 оны II улиралд | Үндэсний илтгэл НҮБ-д хэлэлцүүлэхээр хүргэгдсэн байна | НХХЯ | ХЗДХЯ, ГХЯ, СЯ, БСШУЯ | Улсын төсөв |
| | | | 7. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр доромжлон хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг гутаан харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийн талаарх үндэсний анхдугаар илтгэлийг бэлтгэх; | 2007 оны I улирал | Үндэсний илтгэл НҮБ-д хэлэлцүүлэхээр хүргэгдсэн байна | ХЗДХЯ | Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Хууль зүйн үндэсний төв | Улсын төсөв |
| | | | 8. "Хүүхдийн эрхийн тухай конвенц"-ийн хэрэгжилтийн талаар үндэсний илтгэлийг бэлтгэх; | 2007 оны IY улиралд | Үндэсний илтгэл НҮБ-д хэлэлцүүлэхээр хүргэгдсэн байна | НХХЯ | Хүний эрхийн үндэсний комисс, Шадар сайдын ажлын алба, Хүүхдийн төлөө үндэсний газар, Сонгогчдын боловсрол төв | Улсын төсөв |
| | | | 9. "Газрын мины эсрэг Оттавагийн конвенц"-д нэгдэн орох асуудлыг судалж санал боловсруулах. | 2007 оны IY улиралд | Конвенцид нэгдэх эсэх асуудлыг шийдвэрлэсэн байна | ХЗДХЯ | ГХЯ, УИХ-ын Тамгын газар, Хууль зүйн үндэсний төв, Сонгогчдын боловсрол төв | Улсын төсөв |
| 2. | УИХ-ын дотоод механизмын хувьд Хүний эрхийн дэд хороог бие даасан хороо болгож, хуулийн төсөл, УИХ-аас соёрхон батлах, нэгдэн орох олон улсын гэрээ, конвенц бүрт хүний эрхийн үүднээс дүгнэлт гаргаж чуулганд оруулдаг, тэдгээрийг дагаж мөрдөж буйд хяналт шалгалт хийдэг болгох зэргээр эрхийг нь өргөтгөнө | 1.1.1.7 | 1. УИХ-ын Хүний эрхийн дэд хороог бие даасан хороо болгох чиглэлээр санал боловсруулж эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;<br>2. Хорооны дэргэд хуулийн төсөл, нэгдэн орох олон улсын гэрээнд хүний эрхийн үүднээс шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг ажлын хэсэг байгуулж ажиллуулах;<br>3. УИХ– аас төрийн бус байгууллагатай хүний эрхийн асуудлаар хамтран ажиллах үйл ажиллагааг дэмжих эрх зүйн үндсийг бүрдүүлэх чиглэлээр судалгаа хийх | 2008 онд | Хүний эрхийн бие даасан хороо байгуулагдаж УИХ-аас батлагдан гарах хууль тогтоомж хүний эрхийг хангах зарчимтай нийцэж байгаа эсэхэд хяналт тавих боломж бүрдэнэ | УИХ-ын Тамгын газар | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, ХЗДХЯ | Улсын төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Хүний эрхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийн биелэлтийн талаарх яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын тайланг нэгтгэн УИХ-ын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар нээлттэй хэлэлцэн дүгнэж, зөрчлийг арилгах арга хэмжээ авч байна | 1.1.1.6 | 1. Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг товчлон хялбаршуулан бэлтгэж, олон нийтэд сурталчлан таниулах;<br>2. Тухайн жилийн Ш улиралд орон нутгаас бүсчлэн тайлан авч, нэгтгэн УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанд оруулах;<br>3. Тодорхой чиглэл тус бүрээр яам, агентлагуудаас тайлан авч нэгтгэн УИХ-ын холбогдох Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд оруулж танилцуулан, дүгнэлт гаргуулан, холбогдох арга хэмжээ авах | Жил бүр | Яам, агентлаг, аймаг, нийслэл дэх хүний эрхийг хангах эрх зүйн орчин сайжирна | УИХ-ын Тамгын газар | ХЗДХЯ, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн салбар хороод | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 4. | Улсын Их Хурлын Байнгын хороо бүр хариуцсан салбар, хуралдах хуулийн төсөл, олон улсын гэрээнд хүний эрхийн асуудлаар дүгнэлт гаргадаг, түүндээ судлаач, мэргэжилтний саналыг авч тусгадаг механизм бүрдүүлнэ | 1.1.1.8 | 1. УИХ-ын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах | 2007 оны IY улиралд | УИХ-аас гарч буй шийдвэр нь хүний эрхийг хангахад бүрэн чиглэгдсэн байна | УИХ-ын Тамгын газар | ХЗДХЯ, "Нээлттэй нийгэм форум" ТББ | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 5. | Хүний эрхийн боловсролын төлөв байдал, хэрэгцээ, шаардлага, хамрах хүрээг судалсны үндсэн дээр хүн ам, төрийн албан хаагчид, удирдах ажилтан, бүх шатны сургуулийн сурагч, оюутны хүний эрхийн албан ба албан бус сургалтын тогтолцоог бүрдүүлж, энэ асуудлаар үндэсний мэргэжилтэн, сургагчдыг бэлтгэх дэд хөтөлбөр гарган хэрэгжүүлэх | 1.1.2.6 | 1. Хүний эрхийн албан ба албан бус сургалтын тогтолцооны загвар боловсруулж, холбогдох шийдвэр гаргах;<br><br>2. Эрх бүхий албан тушаалтны дунд хүний эрхийн албан ба албан бус тогтолцооны талаар уулзалт семинарыг салбар чиглэлээр зохион байгуулах;<br><br>3. Хүний эрхийн асуудлаар мэргэшсэн үндэсний мэргэжилтэн, сургагч бэлтгэх дэд хөтөлбөр боловсруулж, холбогдох шийдвэрийг гаргах | 2008 оны I улиралд | Тогтолцоог бүрдүүлсэн байна | БСШУЯ | ХЗДХЯ, Хүний эрхийн үндэсний комисс, Хууль зүйн үндэсний төв, Сонгогчдын боловсрол төв, "Эмнести Интернешнл" ТББ, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо | Олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцийн хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой заалтуудын биелэлтийн талаар НҮБ-ын холбогдох байгууллагад гаргадаг Засгийн газрын илтгэлтэй зэрэгцүүлэн "Хөндлөнгийн илтгэл" оруулж хэлэлцүүлэх боломжийг судалж, шийдвэрлэнэ | 1.1.3.2.4<br>1.1.5.6 | 1. Төрийн бус байгууллагууд хүний эрхийн талаархи Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийн биелэлтийн талаар нэгдсэн тайлан гаргаж, Улсын Их Хуралд хөндлөнгийн илтгэлийн хэлбэрээр илгээхийг дэмжсэн эрх зүйн орчин бий болгох чиглэлээр ажиллах;<br>2. Засгийн газрын тайлантай зэрэгцүүлэн "Хөндлөнгийн илтгэл" гаргах боломжийг судлах | 2008 оны I улирал | Олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийн талаархи "Хөндлөнгийн илтгэл" гарах үйл явц тогтворжсоноор Засгийн газар гэрээ, конвенцийн бодит хэрэгжилтэд илүү анхаардаг болно | Хүний эрхийн үндэсний комисс | ХЗДХЯ, "Нээлттэй нийгэм форум" ТББ | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| **Хүний хувийн эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр** | | | | | | | | |
| 7. | Эмэгтэйчүүд, насанд хүрээгүй болон 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оноохыг хоригласон Эрүүгийн хуулийн заалтыг хэвээр хадгалахын зэрэгцээ уг ялыг оногдуулдаг хэргийн төрлийг цөөрүүлэх, хэтдээ ялын төрлөөс хасах чиглэл баримтлах | 2.1.1.1 | 1. Эрүүгийн хуульд цаазаар авах ял оногдуулах гэмт хэргийн төрлийг судалж, энэ төрлийн ял оногдуулах гэмт хэргийн тоог цөөрүүлэх чиглэлээр санал боловсруулах;<br>2. Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн хорих нөхцөл, тэдэнтэй хүнлэг, энэрэнгүй харьцах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох | 2007 оны Ш улирал | Цаазаар авах ял оноох хэргийн төрөл багасах боломж бүрдэнэ | ХЗДХЯ | Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Хууль зүйн үндэсний төв, "Эмнести Интернэшнл" ТББ, "Хүний эрх, хөгжил төв" ТББ | Улсын төсөв болон олон улсын байгууллагын санхүүжилт |
| 8. | Гэмт хэрэгт холбогдсон этгээд хэргээ шүүхээр аль болох богино хугацаанд шийдвэрлүүлэх, түүнийг цагдан хорьж мөрдөн шийдвэрлэх явдлыг өргөн хэрэглэхгүй байх үүднээс хорьж мөрдөх хуулийн хугацааг ардчилсан улс орнуудын жишгийг харгалзан богиносгож, уул хугацааг сунгах үндэслэлийг аль болохоор хязгаарлах | 2.1.2.5 | 1. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан цагдан хорих, цагдан хорьж мөрдөх хугацаа, түүнийг сунгах журмын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх;<br>2. Цагдан хорих, цагдан хорьж мөрдөх хугацаа, түүнийг сунгах бусад орны дэвшилтэт туршлагыг судлах;<br>3. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах. | 2007 оны I улирал | Цагдан хорих болон эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийн хугацаа богиносож ардчилсан улс орнуудын жишигт хүрснээр хүний халдашгүй чөлөөтэй байх нөхцөл сайжирна | УЕПГ | ХЗДХЯ, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Хууль зүйн үндэсний төв | Олон улсын байгууллагын санхүүжилт |
| 9. | Хараа хяналтгүйгээс амь нас, эрүүл мэнд нь хохирч болзошгүй хүүхдийг хаяг тогтоохоор түр саатуулах хуулийн хугацааг богиносгож, тэднийг төрийн болон төрийн бус байгууллагын асрамж, халамжид шилжүүлэхтэй холбогдсон зохицуулалт хийнэ | .2.1.2.4 | 1. Цагдаагийн байгууллагаас хараа хяналтгүй гадуур амьдарч байгаа хүүхдүүдийн бүртгэлийг гаргах;<br>2. Иргэний бүртгэл, мэдээллийн төвөөс Цагдаагийн байгууллагатай хамтран тэдгээр хүүхдүүдийг иргэний бүртгэлд хамруулах;<br>3. Халамжийн төвүүдэд тэдгээр хүүхдүүдийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах | 2007 оны I улирал | Хараа хяналтгүй гадуур тэнэж байгаа хүүхдүүд бүгд иргэний бүртгэлтэй болж, халамжийн төвүүдэд амьдрах боломжтой болсон байна | ХЗДХЯ | НХХЯ, Хүүхдийн төлөө үндэсний газар, Цагдаагийн ерөнхий газар, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв | Олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10. | Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр доромжлон хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг гутаан харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн заалтыг практикт нэвтрүүлж хэвшүүлэх, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт заавар, зөвлөмж өгч, сургалт явуулж, тэдний хариуцлагыг тодорхой болгох | 2.1.2.8 | 1. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр доромжлон хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг гутаан харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн талаар цагдаагийн болон хорих байгууллагын ажилтнууд, түүнчлэн шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн дунд нийслэлд 5 удаа, орон нутагт бүсчлэн 3 удаагийн сургалт зохион байгуулах;<br>2.Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаанд зайлшгүй баримтлах удирдамжийн төслийг боловсруулах;<br>3.Конвенцийн талаар сургалтын богино хэмжээний кино хийх, гарын авлага, товхимол гаргах;<br>4.Үндсэний хууль тогтоомжийг Конвенцид нийцүүлэх чиглэлээр судалгаа хийж, холбогдох хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах;<br>5. Хүний эрхийн талаархи олон улсын гэрээ, конвенцид нэгдэх, гэрээний биелэлтийг шалгах, тайлагнах, мэдээлэх;<br>6. Иргэний нийгмийн байгууллагуудад хорих байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр сургалт зохион байгуулах | 2007 оны IY улиралд | Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, хууль хяналтын байгууллагын албан хаагчид болон олон нийтийн конвенцийн талаархи мэдлэг, мэдээлэл сайжирна. | ХЭДХЯ | Хүний эрхийн үндэсний комисс, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хууль зүйн үндэсний төв, "Эмнести интернэшнл" ТББ, "ХЭҮТ" ТББ | Олон улсын байгууллагын санхүүжилт |
| 11. | Цагдан хорих, албадан саатуулах, баривчлах байр, хорих ангиудад аттестатчилал явуулж, хуулийн шаардлага хангахгүй, хүний эрх хохироож буй байруудын нөхцөлийг өөрчлөн сайжруулах арга хэмжээ авч, бүх хэлбэрийн хорих байр, газруудын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлэх | 2.1.2.14 | 1. Цагдан хорих, албадан саатуулах, баривчлах байр, хорих ангиудад аттестатчилал явуулах журам боловсруулж, журмын дагуу эдгээр газруудыг 2 жил тутам аттестатчилж байх;<br>2. Цагдан хорих, албадан саатуулах, баривчлах байруудад нэвтрэх журмыг шинэчилж, мөрдүүлэх;<br>3.Цагдан хорих төвийн эрүүл ахуйн нөхцөл /гэрэлтүүлэг, агааржуулалт/- ийг сайжруулах, телекамерийн хяналтыг нэвтрүүлэх;<br>4.Цагдан хорих төвд өмгөөлөгч ажиллах боломжийг бий болгох;<br>5. Олон улсын стандартад нийцсэн цагдан хорих байрыг төв, орон нутагт шинээр барьж байгуулах асуудлыг шийдвэрлэх; | 2007-2008 онд | Хүний эрхийг хохироож буй цагдан хорих, албадан саатуулах, баривчлах байруудыг шинэчлэн сайжруулах нөхцөл бүрдэнэ<br><br>Олон нийтийн хяналт сайжирч улмаар дээрх байруудад хүний эрх зөрчигдөх явдал арилж, хүний халдашгүй чөлөөтэй байх эрх хангагдана | ХЭДХЯ | Аймаг, нийслэлийн ИТХ, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, "Эмнести интернэшнл" ТББ | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 6. Олон улсын стандартад нийцсэн онцгой дэглэмтэй хорих ангийг шинээр барьж байгуулах асуудлыг шийдвэрлэх;<br>7.Эрүүлжүүлэх байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах. | | | | |
| 12. | Иргэн өөрийгөө өмгөөлөх, мэргэжлийн өмгөөлөгчөөр болон өмгөөлөл эрхлэх зөвшөөрөлгүй боловч итгэл бүхий хүнээр өөрийгөө өмгөөлүүлэх эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлэх;<br><br>Төлбөрийн чадваргүй иргэдийг өмгөөлөх, тэдэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, зардлыг төсвөөс санхүүжүүлэх | 2.1.4.1<br><br>2.1.4.2 | 1.Өмгөөллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах;<br><br>2.Төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж батлуулах;<br><br>3. Өмгөөллийн туслалцааны төвүүдийг нийт аймаг, дүүргүүдэд байгуулах. | 2007 оны II улиралд | Иргэн өөрийгөө өмгөөлүүлэх эрх зүйн нөхцөл бүрдэж өөрийгөө өмгөөлөх, эрх зүйн туслалцаа авах эрх хангагдана.<br><br>Төлбөрийн чадваргүй иргэд өмгөөлүүлэх, эрх зүйн туслалцаа авах боломж бүрдэнэ | ХЗДХЯ | Монголын өмгөөлөгчдийн холбоо, "Нээлттэй нийгэм форум" ТББ | Олон улсын байгууллагын санхүүжилт |
| 13. | Зохих сан бий болгох, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах даатгалд хамруулах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, энэ ээлжинд хариуцагч нь тодорхойгүй, эсхүл төлбөрийн чадваргүй иргэдийн хохирлыг төр урьдчилан төлж хариуцагчаар нөхөн төлүүлэх журмыг хуулиар тогтоон хэрэгжүүлж цаашид боловсронгуй болгох | 2.1.5.1 | 1. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэнд нөхөн төлбөр олгох тухай хуулийн төслийг боловсруулах;<br>2. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах сангийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх;<br>3. Гэрч, хохирогчийг хамгаалах талаар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах;<br>4.Төрийн хариуцлагын сан байгуулах. | 2006 оны IY улиралд<br><br>2007 оны эхний хагас жилд | Гэмт хэргийн улмаас хохирсон иргэнд нөхөн төлбөрийг олгох, гэмт хэргийн хохирогч, гэрчийг хамгаалах тогтолцоотой болно | ХЗДХЯ | СЯ, Улсын ерөнхий прокурорын газар, Улсын дээд шүүх, Хууль зүйн үндэсний төв | Улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 14. | Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс хэрэгт эдэлсэн хүмүүст хилсээр хоригдсон хоног тутамд ногдох сэтгэл санааны төлбөрийн хэмжээг тогтоож мөрдүүлэх | 2.1.3.4<br>2.1.5.1 | 1. Хууль бусаар эрх нь зөрчигдсөн хүмүүст сэтгэл санааны хохирлын нөхөн олговрын хэмжээг нарийвчлан тогтоож, холбогдох хуульд өөрчлөлт оруулах;<br>2. Энэ талаар Улсын дээд шүүхээс хуулийн тайлбарыг шинэчлэн гаргуулах;<br>3. Хууль бусаар эрх нь зөрчигд-сөн хүмүүсийн сэтгэл санааны хохирлыг барагдуулсан байдлыг 2002-2006 оны байдлаар нийслэлийн хэмжээнд судлах; | 2008 онд | Сэтгэл санааны нөхөн олговор олгодог журам, тогтолцоотой болж бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх бүрэн хэрэгжинэ | ХЗДХЯ, Хүний эрхийн үндэсний комисс | Улсын дээд шүүх, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хууль зүйн үндэсний төв | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 4. Гэмт хэргийн улмаас амь нас хохирсны нөхөн төлбөр олгох асуудлыг судлах. | | | | | |
| 15. | Иргэд өөр аймаг, нийслэл, сум, дүүрэгт байнга буюу түр шилжин суурьшигчдын нийтийн үйлчилгээнд ногдох зардлыг өмнө нь оршин сууж байсан аймаг, сумын төсвөөс шинээр суурьшсан газарт шилжүүлдэг журмыг тогтоох | 2.1.6.1 | 1.Нийтийн үйлчилгээний зардлыг шилжүүлэх тухай журмыг боловсруулах.<br><br>2. Шилжилт хөдөлгөөний хууль боловсруулах асуудлыг судлах. | 2007 оны II улирапд | Шилжин суурьшигчдын нийтийн үйлчилгээнд хамрагдах бэрхшээл арилна | НХХЯ | ХЗДХЯ, Нийслэлийн ИТХ, Хүний эрхийн үндэсний комисс, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо | Улсын төсөв |
| 16. | Сүм хийд байгуулах зөвшөөрлийн тогтолцоог сайжруулж, үндэслэл, журмыг боловсронгуй болгох | 2.1.7.2 | Одоогийн зөвшөөрлийн тогтолцоонд хяналт- шинжилгээ хийж, Сүм хийдийн харилцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлах | 2008 оны I улирапд | Сүм хийд байгуулах зөвшөөрлийн тогтолцоо боловсронгуй болж иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрхээ эдлэх нөхцөл сайжирна | ХЗДХЯ | Хүний эрхийн үндэсний комисс, Аймаг, Нийслэлийн ИТХ | Улсын болон орон нутгийн төсөв |
| | **Хүний улс төрийн эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр** | | | | | | | |
| 17. | Сонгуулийн тогтолцоо, үйл явцын (процессын) журмыг иргэдийн бие даасан оролцоог хангаж, чадварлаг Улсын Их Хурал бүрдүүлэхэд болон төлөөлөх ардчиллыг хэрэгжүүлэхэд чиглүүлэн боловсронгуй болгох | 2.2.1.1 | 1. Сонгогчдын боловсролыг сайжруулах сургалтын тогтолцоог бий болгож, үйл ажиллагаар тогтмолжуулах;<br><br>2. Улсын дээд шүүхээс Сонгуулийн тухай хуулийн зарим зүйл заалтад тайлбар гаргуулах. | 2007 оны II улирлаас эхлэн тогтмол<br><br>2007 оны I улирапд | Сонгогчдын улс төрийн боловсрол дээшилж, чадварлаг Улсын Их Хурал бүрдэнэ | СЕХ | БСШУЯ,Улсын дээд шүүх, Сонгогчдын боловсрол төв, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо | Олон улсын байгууллагын санхүүжилт |
| 18. | Сонгуулийн болон улс төрийн томилогдох албан тушаалд нэр дэвшигчдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх бодлого баримтлах | 2.2.1.3 | 1. Эмэгтэйчүүдийн улс төрийн идэвх санаачилгыг сайжруулах чиглэлээр улс төрийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн оролцоо, эмэгтэйчүүдийн албан тушаал дэвших өнөөгийн боломж зэрэг сэдэвт семинарыг зохион байгуулах | 2007 оны I, II улиралд | Оролцоо дээшилснээр улс төрийн болон сонгуульт албан тушаал эрхлэх эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэнэ | ХЗДХЯ | НХХЯ,Хүний эрхийн үндэсний комисс, Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хороо, Монголын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахын эсрэг үндэсний байгууллага, Сонгогчдын боловсрол төв | Олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | Хүн амын шилжилт хөдөлгөөн болон бичиг баримтын зөрчилтэй зэрэг шалтгаанаар сонгуульд санал өгөхийг тулгэлзүүлэх, нэрсийн жагсаалтаас орхигдуулах зэргээр иргэдийн саналаа өгөх эрхийг хөсөрдүүлэхийг нэгтэй зөрчилд тооцон хүлээлгэх хариуцлагыг чангатгах, үг зөрчлөөс сэргийлэх арга хэмжээ авах | 2.2.1.5 | 1. Улсын хэмжээнд иргэний бичиг баримтын үзлэгийг явуулж, тодорхой хаяггүй иргэдийг хаягжуулах;<br>2 Иргэний үнэмлэх олгох үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ хийж, орчин үеийн техник, технологи, стандартад нийцсэн иргэний үнэмлэхийн шинэ загварын талаар судалгаа хийх;<br>3. Иргэний бичиг баримтын зөрчилгүй байж төрөөс иргэдэд хүргэх нийгмийн үйлчилгээг бүрэн хүртэж байх эрхийг иргэдэд төлөвшүүлэх;<br>4.Цахим засаглалыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх. | 2008 оны I улиралд | Сонгуулийн явцад сонгогчдын тоо болон нэрсийн жагсаалтын будлиан гарах боломж хаагдана<br><br>Иргэдийн сонгох, сонгогдох эрх хангагдана | ХЗДХЯ | Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн үндэсний комисс, Нийслэлийн ИТХ | Улсын төсөв |
| 20 | Төрийн захиргааны болон тусгай алба хаших нөхцөл болзол нь нийт иргэний хувьд адил тэгш байх үндсэн дээр төрийн албанд иргэдийг шалгаруулж авах, мэргэшүүлэн ажиллуулахдаа намчирхах, нутгархах, танил талаар дэмжих үзэгдэл төрийн үзэл бодлоор нь ялгаварлах, авилгал авах зэрэг хууль бус үйлдэлд өртөхгүй, тийм хандлага гаргахгүй байх баталгаа бий болгох;<br><br>Төрийн албаны зөвлөлийг хараат бус ажиллуулж, төрийн албанд томилох, дэвшүүлэх, бууруулах, шилжүүлэх, халахад гарч байгаа хүний эрхийн зөрчлийг арилгаж, үг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах | 2.2.2.1<br><br>2.2.2.4 | 1.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах;<br><br>2. НҮБ-ын Авилгалын эсрэг конвенц болон Авилгалын эсрэг хууль тогтоомжийн талаар төрийн захиргааны болон тусгай албан хаагчдад зориулсан сургалтыг төв, орон нутагт зохион байгуулах;<br><br>3. Авилгалын эсрэг хууль тогтоомжийн талаар гарын авлага, материал боловсруулж олон нийтэд сурталчлах. | 2007 оны II улиралд<br><br>2007-2008 онд | Төрийн албаны тухай хууль тогтоомжоор төрийн алба хаах нөхцөл болзол нь нийт иргэний хувьд адил тэгш байгаа эсэх, төрийн албанд иргэдийг шалгаруулж авах, мэргэшүүлэн ажиллуулахад хуулиар тогтоосон журмын хэрэгжилтийн талаар бодитой үнэлгээ гарна<br><br>Төрийн албаны үйл ажиллагаан дахь хүний эрхийн зөрчил багасна | Төрийн албаны зөвлөл | ХЗДХЯ, УИХ-ын Тамгын газар | Улсын төсөв |
| 21 | Аймаг, сум, нийслэл, дүүргийн хэмжээнд хүний эрхийг хангах талаар нийтээр дагаж биелүүлэх хэм хэмжээ, түүнийг зөрчсөн тохиолдолд авах арга | 2.2.3.2 | 1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх Үндэсний хөтөлбөрийн салбар хороодоос энэ талаархи саналыг авч нэгтгэн шийдвэрлэх; | 2007 оны 1 дүгээр сараас эхлэн | Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд нийтээр дагаж мөрдөхөөр эрх бүхий албан тушаалтнаас | ЗГ-ын ХЭГ | ХЗДХЯ, Аймаг, нийслэл, сум дүүргийн Хүний | Улсын төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээг тодорхойлсон шийдвэр гаргах, нутаг дэвсгэрийнхээ хүн амын болон тэдний бүлгийн эрх, ашиг сонирхлын асуудлыг шийдвэрлэх, хамгаалах эрхийг өргөтгөх | | 2. Аймаг, нийслэлийн Засаг даргын нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан шийдвэрүүд Хөтөлбөрийн зорилтод нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, гаргасан зөрчлийг цаг тухайд нь арилгуулж байх | Жил бүр | гаргаж буй эрх зүйн акт нь Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийн зорилттой нийцсэн байна | | эрхийн салбар хороод, Үйлдвэрчний эвлэлийн орон нутгийн байгууллагууд | |
| 22. | Ажиллагчид үйлдвэрчний эвлэлд нэгдэн ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагын эзэмдгэлийн дур зоргын үйл ажиллагаагаар илчлэх, нацаах зэргээр эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах механизмыг сайжруулах | 2.2.4.2 | 1.Чөлөөтэй эвлэлдэн нэгдэх болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай конвенцийг сурталчлах;<br>2.Гадаадын хөрөнгө оруулалттай нэг аж ахуйн нэгжийг сонгож хяналт шалгалт хийх;<br>3. Хувийн хэвшлийн зарим байгууллагуудын ажил олгогч, ажиллагчдад хүний эрхийн талаарх /Хөдөлмөрлөх эрх болон ажлын байран дээрх аливаа дарамт шахалтын эсрэг/ системчилсэн сургалтыг зохион байгуулах;<br>4. Даяаршлын тунхаг, Бизнесийн байгууллагын үйл ажиллагаан дахь НҮБ-ын хүний эрхийн хэм хэмжээний талаарх системчилсэн сургалтыг зохион байгуулах;<br>5. ҮЭ-үүдээс хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр судалгаа хийх. | 2007 оны Ш улиралд<br>2007 оны П улиралд<br>2007 онд | Хувийн хэвшлийн байгууллагуудад хүний эрх зөрчигдөх явдал багасаж, ажиллагсдын эрхээ хамгаалах мэдлэг дээшилнэ | НХХЯ | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хууль зүйн үндэсний төв, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, "Эмнести интернэшнл" ТББ | Улсын төсөв<br>Тухайн аж ахуйн нэгж болон олон улсын байгууллагын санхүүжилт |
| 23. | Хүний эрхийн асуудлаар төрийн бус байгууллагууд санал солилцож, зөвлөмж, хөндлөнгийн илтгэл гаргах, ярилцлага, уулзалт зохион байгуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэх, энэ ажилд зориулсан сургалтын төв, мэдээллийн сан байгуулж ажиллуулахыг бодитойгоор дэмжинэ | ·2.2.4.5 | 1. Хүний эрхийн сургалтын төв, мэдээллийн сан байгуулах талаар төрийн бус байгууллагуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулж, гарсан зөвлөмжийн дагуу зохих арга хэмжээ авах | 2007 оны I улиралд | Хүний эрхийн чиглэлийн ТББ-уудын үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй болж төрийн болон төрийн бус байгууллагын хүний эрхийн чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирна | ХЗДХЯ | Хүний эрхийн үндэсний комисс, Хууль зүйн үндэсний төв, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо | Олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 24. | Нууц хамгаалах хуульдаар тогтоосон илүүц хязгаарлалтыг арилгах зэргээр төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, энэ талаар иргэд, хэвлэл мэдээллийн ажилтны хүсэлт шаардлагаар мэдээлэл гаргаж өгөх үүрэг хариуцлага, иргэдээс мэдээлэл олж авах, түгээх эрхийг нь нарийвчлан тодорхойлсон хууль эрх зүйн үндсийг бүрдүүлнэ | 2.2.5.1 | "Мэдээллийн эрх чөлөөний тухай" хуулийн төслийг боловсруулах ба энэ хуулийн төсөлд нууцтай холбоотой зохицуулалтыг шинээр оруулах. | 2006 оны Ш улиралд | Мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зүйн үндэс бүрдэнэ. | ХЗДХЯ | УИХ-ын Тамгын газар, "Глоб интернейшнл" ТББ | Улсын төсөв |
| 25 | Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбогдох бүх хууль тогтоомжид судалгаа хийж, зөрчилтэй зүйл, заалтыг хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох | 2.2.5.4 | 1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаарх хууль тогтоомжид хяналт- шинжилгээ хийх;<br>2. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах;<br>3. Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд Улсын дээд шүүхээс тайлбар гаргуулах. | 2007 онд | Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаарх хууль тогтоомж боловсронгуй болно | ХЗДХЯ | Улсын дээд шүүх, Хэвлэл мэдээллийн байгууллагууд, Хууль зүйн үндэсний төв, "Глоб интернейшнл" ТББ | Олон улсын байгууллагын санхүүжилт |
| 26 | Үндэсний цөөнх эх хэлээрээ мэдээлэл авах, түгээх боломжийг хангана | 2.2.5.7 | 1. Баян-Өлгий аймгийн радио станцыг шинэчлэн сайжруулах чиглэлээр ажиллах;<br>2. Баян-Өлгий аймгийг орон нутгийн телевизтэй болгоход дэмжлэг үзүүлэх асуудлыг судлах. | 2007-2008 онд | Үндэсний цөөнх эх хэлээрээ мэдээлэл авах, түгээх боломжоор хангагдсан байна. | Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар | БСШУЯ, Баян-өлгий аймгийн ЗДТГ, "Глоб интернейшнл" ТББ | Олон улсын байгууллагын санхүүжилт |
| 27 | Төрийн болон төрийн бус байгууллага боловсон хүчний бодлого, үйл ажиллагаагаа жендерийн тэгш байдлыг хангах зарчимд нийцүүлэх, хөгжлийн хөтөлбөрүүдэд жендерийн дүн шинжилгээ хийж, тэдгээр хөтөлбөрт эмэгтэйчүүдийн улс төр, нийгэм, эдийн засаг, гэр | 2.2.6.1 | 1.Хөгжлийн хөтөлбөрүүдэд жендерийн дүн шинжилгээ хийх;<br>2. Эдгээр хөтөлбөрүүдэд эмэгтэйчүүдийн улс төр, нийгэм, эдийн засаг, гэр бүлийн харилцаанд эрх тэгш оролцоход нь үзүүлэх нөлөөллийг үнэлэх шалгуурын төслийг боловсруулах | 2007-2008 онд | Жендерийн тэгш байдлыг хангах нөхцөл сайжирсан байна | Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороо | ЗГ-ын ХЭГ, НХХЯ, ТББ-ууд | Олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүлийн харилцаанд эрх тэгш оролцоход нь узүүлэх нөлөөллийг үнэлэх шалгуурыг боловсруулан ажилдаа нэвтрүүлнэ | | | | | | | |
| 28 | Эмэгтэйчүүд, хүүхдийг элдэв дарамтлах, доромжлох, хүнлэг бус хандах, тарчилган зовоох зэрэг хүчирхийллийн бүх хэлбэр, гэр бүлийн шалтгааныг илрүүлэн арилгах талаар төрийн болон төрийн бус байгууллагын хамтын чармайлтыг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон Засгийн газрын түвшинд нэгтгэн зохицуулж, үр дүнг жил бүр мэдээлж байна. Ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдах, биеэ үнэлэхийг албадах, хиллэлэх /хилийн болох/ зэргийг хатуу хориглохын хамт гэмт үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, хүчирхийллийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, байнгын хүчирхийлэлд өртөж болзошгүй эмэгтэйчүүд, хүүхдийг асран хамгаалах талаар гүйцэтгэх эрх мэдлийн зохих байгууллагуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлнэ | 2.2.6.4 | 1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулъ батлагдсантай холбогдуулан холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах;<br><br>2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг судалж, хяналт-шинжилгээ хийх, гарч буй үр дүнг нийтэд нээлттэй хэлэлцүүлэх;<br><br>3. Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах чиглэлээр үдирдамж боловсруулах | 2007-2008 онд | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт боловсронгуй болсон байна | ХЗДХЯ | НХХЯ, Цагдаагийн ерөнхий газар, Хүний эрхийн үндэсний комисс, Хууль зүйн үндэсний төв Хүчирхийллийн эсрэг үндэсний төв | Олон улсын байгууллагын санхүүжилт |
| 29 | Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц зэрэг Монгол Улсын олон улсын гэрээнүүдийг гуйвалтгүй биелүүлж, энэ талаар НҮБ-ын зүгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газар анхаарлдаа авна. Түүнчлэн эмэгтэйчүүдийн эсрэг хүч хэрэглэх явдлыг устгах тухай тунхаглал зэрэг эмэгтэйчүүдийн эрхийг хөхиүлэн дэмжих талаар байгуулагдсан бүх хэлэлцээрт нэгдэх арга хэмжээ авах | 2.2.6.6 | 1. НҮБ-ын гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын үр дүнг дээшлүүлж, хяналт тавих ажлыг тогтмолжуулах;<br><br>2. Эмэгтэйчүүдийн эсрэг хүч хэрэглэх явдлыг устгах тухай Тунхаглалд нэгдэх асуудлыг судлан үзэж, санал боловсруулах;<br><br>3. Эмэгтэйчүүдийн эсрэг хүч хэрэглэсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, шийдвэрлэж буй байдал болон энэ хэргийг шийдвэрлэхэд баримталж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт- шинжилгээ хийж, зохих арга хэмжээ авах | 2007 онд | Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилт бүрэн хангагдана. Эмэгтэйчүүдийн эсрэг хүч хэрэглэх явдлыг устгах тухай тунхаглалд нэгдэх асуудал шийдвэрлэгдэнэ. | НХХЯ | ХЗДХЯ, ГХЯ, НХХЯ, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв болон ТББ-ууд | Олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийгэм, соёл, эдийн засгийн эрхийн хүрээнд** | | | | | | | | |
| 30. | Хүний эрх, хөгжил, боловсрол, эрүүл мэнд зэрэг бусад аливаа асуудлаар гаргасан улс, орон нутгийн түвшний хөтөлбөр, төлөвлөгөө, үндсэн чиглэл гэхчлэн программчилсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагуудыг дүрмийн зорилтын дагуу идэвхтэй оролцуулах | 1.1.5.2 | 1. Шийдвэрийг төрөлжүүлэн гаргаж төрийн бус байгууллагад хүргүүлэх;<br>2. Төрийн бус байгууллагуудтай сэдэвчилсэн уулзалт ярилцлагыг 2 удаа зохион байгуулж цаашид шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах;<br>3.Хэрэгжилтийн явцад ТББ-аас хөндлөнгийн хяналт тавьж Хороонд санал, илтгэл ирүүлж байх | 2007 онд | Шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих боломж бүрдэнэ | ЗГ-ын ХЭГ, ХЗДХЯ | Яамд, агентлаг, орон нутгийн ЗДТГ, орон нутаг дахь ТББ-ууд | Улсын болон орон нутгийн төсөв, ТББ-ын санхүүжилт |
| 31. | ТББ, ялангуяа хүний эрхийг хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, хөдөлгөөн мэдээлэл авах, цуглуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох | 1.1.5.5 | 1.Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар төрийн бус байгууллагуудтай хамтарсан уулзалт ярилцлагыг зохион байгуулж, арга замыг тодорхойлох;<br>2. Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулж, эрх бүхий байгууллагад өргөн барих | 2007 онд | Төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалт боловсронгуй болно | ХЗДХЯ | ЗГ-ын ХЭГ, Хүний эрхийн үндэсний комисс | Улсын төсөв |
| 32. | Хувийн хэвшлээс хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэх, эм, хэрэгслийн үр ашигтай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх болон түүнд оролцоход саад болсон үндэслэлгүй хориглолт хязгаарлалтыг илрүүлэн арилгахыг хөхиүлэн дэмжих | 1.1.6.5 | 1. Хувийн хэвшлийн төлөөлөгчидтэй уулзалт ярилцлага зохион байгуулах;<br>2. Энэ чиглэлээр гарсан тогтоол шийдвэр нь практикт хэрхэн нийцэж буйд судалгаа хийж, хуурамч эм, бэлдмэл үйлдвэрлэх, худалдах, эм, бэлдмэлийн чанарын шаардлага, хадгалалтад тавих хяналтын үр дүнгийн байдалд мониторинг хийж тодорхой арга хэмжээ авах | 2007 онд | Үндэслэлгүй хориглолт арилна | ЭМЯ | ХЗДХЯ, ҮХЯ, хувийн хэвшлийн байгууллагууд | Улсын төсөв, тухайн байгууллагуудын болон ТББ-ын санхүүжилт |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын эздээс өөрийн ажилтагчдад зориулж хүний эрхийг хангах тогтолцоо бий болгох, мэдээлэл, сургалт явуулахад нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх | 1.1.6.7 | 1. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын эздтэй хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлэх талаар уулзалт зохион байгуулах;<br>2.Ажиллагчдад зориулж хүний эрхийн мэдээлэл, сургалт явуулах;<br>3. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын эзэд, хүний нөөцийн ажилтнуудад сургалт явуулах (2 удаа);<br>4. Ажил олгогчоос хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрлөх болон бусад эрхүүдийг зөрчих бүй шалтгаан, нөхцөлийг мэргэжлийн хяналтын, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс тогтмол судлах, хяналт тавьж ажиллах, тэдгээрийг арилгах, энэ үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг идэвхтэй оролцуулах | 2007 оны II улирлаас эхлэн улирал бүр<br>2007 онд<br>2007-2008 онд | Мэдээлэл, сургалтыг тогтмолжуулсан байх<br>Хүний эрх зөрчигдөх явдал багассан байна | ХЗДХЯ<br>НХХЯ | НХХЯ,Хүний эрхийн үндэсний комисс, Хууль зүйн үндэсний төв, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, "Эмнести интернэшнл" ТББ<br>НХХЯ,Хүний эрхийн үндэсний комисс, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо | Улсын төсөв, тухайн байгууллагын болон ТББ-ын санхүүжилт |
| 34 | Амьжиргааны баталгаажих доод түвшинг тодорхойлохдоо хоол хүнс, хувцас хунар, орон гэр, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой наад захын хэрэгцээг харгалзан үзэх ба өнөөгийн үнэ ханшийг мөрдлөг болгох | 2.4.2.1 | 1. Амьжиргааны баталгаажих доод түвшинг тухай бүр шинэчлэн тогтоож байх аргачлалыг боловсронгуй болгох | 2007-2008 онд | Амьжиргааны баталгаажих доод түвшинг хүний наад захын хэрэгцээг хангаж чадахуйц хэмжээнд хүргэнэ | ҮСГ | НХХЯ | Улсын төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | Дундаж тэтгэврийн хэмжээ, түүний дотор бүрэн тэтгэврийн доод хэмжээ, хувь тэнцүүлсэн тэтгэвэр, ердийн өвчин, ахуйн ослын улмаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр, нийгмийн даатгал, халамжийн сангаас олгох жирэмсний, амаржсаны, хүүхэд асрсны болон халамжийн зэрэг тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлж, амьжиргааны доод түвшинг хангахуйц хэмжээнд хүргэх. 1995 оноос өмнө тогтоогдсон тэтгэврийн зөрүүг арилгах, 2020 оноос хойш тогтоогдох тэтгэвэрт зөрүү үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх | 2.4.2.8 | 1. Нийгмийн даатгалаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Халамжийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах;<br><br>2. 1995 оноос өмнө тогтоогдсон тэтгэврийн зөрүүг арилгах;<br><br>3. 2020 оноос хойш тогтоогдох тэтгэвэрт зөрүү үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үе шатыг тодорхойлох | 2007 онд<br><br>2007 онд | Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ хүний амьжиргааны хэрэгцээг хангана. 2020 оноос хойш тэтгэврийн зөрүү үүсэхээс сэргийлэх арга хэмжээг тодорхой үе шатаар хэрэгжүүлэх төлөвлөгөө гарна | НХХЯ | ЗГ-ын ХЭГ, СЯ, ХЗДХЯ | Улсын төсөв |
| 36 | Соёл, урлагийн бүтээлээ өмчлөх эрхийг баталгаажуулах ажлыг хялбаршуулан шуурхай болгох | 2.3.2.4 | Соёл, урлагийн бүтээлээ өмчлөх эрхийг баталгаажуулах ажлыг хялбаршуулан шуурхай болгох арга хэмжээ авах | 2007 онд | Иргэд өөрийн бүтээлийг богино хугацаанд баталгаажуулах боломж бүрдэнэ | ОӨГ | Шадар сайдын ажлын алба | Улсын төсөв |
| 37 | Хөдөлмөр хамгаалал, үйлдвэрлэлийн ариун цэвэр, эрүүл ахуйн улсын хяналтыг урьдчилан сэргийлэх, зөрчлийг таслан зогсооход голлон чиглүүлж үр нөлөөг дээшлүүлэх | 2.4.1.7 | 1. Хөдөлмөрийн болон үйлдвэрлэлийн ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр хамтарсан үзлэг, шалгалт хийх ажлыг тогтмолжуулах;<br><br>2. Зөрчил илэрвэл зөрчил үүсэх болсон шалтгаан нөхцөлд судалгаа хийх, зөрчлийг арилгах чиглэлээр тодорхой арга хэмжээ зохион байгуулах;<br><br>3. Урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, таниан мэдэхүйн арга хэмжээ авах (гарын авлага, товхимол, зурагт хуудас г.м);<br><br>4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай хуулийн төсөл боловсруулах | 2007 оноос эхлэн улирал бүр<br><br>2007 онд | Хөдөлмөр хамгаалал, үйлдвэрлэлийн ариун цэвэр, эрүүл ахуйн улсын хяналт сайжирснаар иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөл дээшилнэ | УМХГ | ХЗДХЯ, НХХЯ, Хууль зүйн үндэсний төв, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 38. | Эдийн засаг, нийгэм, соёл, боловсрол, эрүүл мэнд, экологийн болон бусад салбарын бүх түвшний үндсэн чиглэл, төсөв, хөтөлбөр болон хууль тогтоомжид тусгай хэрэгцээ бүхий хүмүүсийн талаар тодорхой бүлэг, заалт оруулж, тахир дутуу иргэдийн эрх, ашиг сонирхлыг нь хамгаалах хуулиудыг боловсронгуй болгох зэрэг нэмэлт арга хэмжээ авна | 2.4.6.1 | 1. Эрүүл мэндийн тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Онцгой албан татварын тухай, Гаалийн тарифын тухай, Хөдөлмөрийн тухай, Барилгын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Авто тээврийн тухай, Биеийн тамир,спортын тухай, Авто замын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах.<br><br>2. Шүүх, цагдаа болон эрүүл мэнд, соёл, боловсрол зэрэг төрийн үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцаж, ойлголцох дохионы орчуулагчтай болох асуудлыг судлан холбогдох арга хэмжээг авах;<br><br>3. Сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хичээл заах дохионы хэл болон бөрелл бичгээр хичээл заах нарийн мэргэжлийн багш бэлтгэх анги нээж ажиллуулах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авах. | 2007 онд<br><br>2007-2008 онд | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгэмд тэв тухтай сурч, хөдөлмөрлөж, амьдрах боломж бүрдэнэ | Ерөнхийлөгчийн Тамгын газар,<br>ХЗДХЯ<br><br>БСШУЯ | УИХ-ын Тамгын газар, ЗГ-ын ХЭГ, Хүний эрхийн үндэсний комисс<br><br>ХЗДХЯ, ЭМЯ, НХХЯ | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |
| 39. | Гудамж, талбай, нийтийн үйлчилгээний газар, ажлын байр, орон сууцанд тахир дутуу хүмүүст зориулсан тусгай тоноглол, хэрэгсэл байрлуулж тэдний ажиллах, зорчих болон бусад хэрэгцээ хангах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг өргөжүүлэх | 2.4.6.3 | 1. Зарим гудамж, талбай, нийтийн үйлчилгээний газар, ажлын байр, орон сууцанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай тоноглол хэрэгслийг байрлуулах | 2007-2008 онд | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах, зорчих хэрэгцээг хангах нөхцөл бүрдсэн байна | ХЗДХЯ | НХХЯ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, ЭМЯ, БХБЯ | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүний эрхийн талаарх олон улсын гэрээний биелэлт ба мониторинг хийх чиглэлээр | | | | | | | | |
| 40 | Хүний эрхийн талаархи олон улсын гэрээнүүдийг тухайлан судалж ойрын үед Монгол Улс нэгдэн орох шаардлагатай гэрээ, конвенцийн жагсаалт гаргаж шийдвэрлэнэ | 3.1.1.5 | 1.Ойрын хугацаанд нэгдэн орох шаардлагатай гэрээний жагсаалтыг гаргах;<br><br>2.Конвенцид нэгдэн орох талаар судалгаа хийх. | 2007 онд | Хүний эрхийг хангах хууль, эрх зүйн орчин сайжирна | ГХЯ | ХЗДХЯ | Улсын төсөв |
| 41. | Хүний эрхийн үндэсний комиссоос хувь хүний эрх, аюулгүй байдлын талаархи олон улсын гэрээний биелэлтийг шалгах, тайлагнах, мэдээлэх, олон улсын гэрээнд заасан эрх зөрчсөн тухайн гомдлыг хянан шалгаж, зөрчлийг арилгах боломж, үр нөлөөг дээшлүүлнэ | 3.1.2.9 | 1.Хувь хүний эрх, аюулгүй байдлын талаархи олон улсын гэрээний биелэлтийг шалгаж дүгнэлт гаргах хамтарсан ажлын хэсгийг байгуулж ажиллуулах;<br><br>2. Ажлын хэсгээс гарсан дүгнэлтийг үндэслэн холбогдох арга хэмжээг авах | 2007 онд | Олон улсын гэрээ, конвенцид заасан эрхээ хамгаалах эрх зүйн орчин бүрдэнэ | Хүний эрхийн үндэсний комисс | ХЗДХЯ, ГХЯ | Улсын төсөв болон олон улсын байгууллагын санхүүжилт |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2007 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр** | **Дугаар 21** | **Улаанбаатар хот**

### Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн $18^{3}$ дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Дугаржавын Батжаргалыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Д.ОДБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2007 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр** | **Дугаар 22** | **Улаанбаатар хот**

### Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Михлайн Борбаатарыг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД М.СОНОМПИЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2007 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр** | **Дугаар 26** | **Улаанбаатар хот**

### Улсын сайн малчин шалгаруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2007 онд 35 хүртэлх малчныг "Улсын сайн малчин"-аар шалгаруулан шагнасугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 150 дугаар тогтоолоор баталсан "Улсын сайн малчин шалгаруулах журам"-ын 2 дугаар заалтыг 2007 онд дагаж мөрдөхгүй байхаар тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.ТЭРБИШДАГВА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2007 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр** | **Дугаар 27** | **Улаанбаатар хот**

### Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын Засгийн газарт өгсөн чиглэлийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, түүний үр шимийг иргэддээ хүртээх, улс орны хөгжлийг түргэтгэх зарим асуудлаар Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяраас өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.1, 9.1.2, 9.1.5, 9.1.6, 9.1.8 дахь заалт, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3 хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн болон хувийн хөрөнгөөр геологи, хайгуулын ажил хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээг улс орны эрх ашигт нийцүүлэн тогтоох талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй хэлэлцээр хийх саналын хувилбаруудыг боловсруулж Засгийн газарт оруулахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Батболд, Сангийн сайд Н.Баяртсайхан, Үйлдвэр, худалдааны сайд Б.Жаргалсайхан нарт тус тус даалгасугай.

2. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн дагуу ураны ордод төрийн хяналтыг олон улсын нийтлэг жишгийн дагуу тогтоож, оновчтой хэлбэрээр ашиглах талаар гадаад улсын төрийн байгууллага, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төрийн өмчийн компаниудтай гэрээ, хэлэлцээр хийх санал боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Үйлдвэр, худалдааны сайд Б.Жаргалсайхан, Цөмийн энергийн комисс (С.ЭНХБАТ)-т даалгасугай.

3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах үеийн төрийн оролцоог төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компаниар дамжуулан хэрэгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулснаар төрд ногдох ашгийг эрдэнэсийн сан байгуулан төвлөрүүлж, тодорхой хэсгийг иргэдэд "Эх орны хишиг" хэмээн хүртээх арга хэлбэр, холбогдох хууль тогтоомж, журмын төсөл боловсруулан Засгийн газарт оруулахыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд даалгасугай.

4. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахад шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор найдвартай түнш, хөрөнгө оруулагчидтай ил тод, шударга, нээлттэй, харилцан ашигтай хамтран ажиллаж олон улсын жишгийн дагуу хувьцаа гаргах, үнэт цаас, урьдчилсан төлбөр хийлгэх зэрэг арга хэлбэрийг ашиглах талаар Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банк, Хөрөнгийн биржтэй хамтран тодорхой санал боловсруулахыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Үйлдвэр, худалдааны сайд Б.Жаргалсайхан нарт даалгасугай.

5. Томоохон орд газруудыг ашиглахтай холбогдуулан ус, дулаан, цахилгааны хангамж, авто болон төмөр зам, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийг байгуулах оновчтой шийдлийг гаргаж энэ оны 3 дугаар сарын 31-ний дотор Засгийн газарт танилцуулахыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэл, Түлш, эрчим хүчний сайд Б.Эрдэнэбат нарт даалгасугай.

6. Томоохон орд газруудыг ашиглах явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар нарийвчилсан үнэлгээ хийж дүгнэлтийг Засгийн газарт танилцуулахыг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатарт даалгасугай.

7. Засгийн газраас боловсруулсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичигт эрдэмтэн судлаачдаас ирүүлсэн саналыг тусган эцсийн хувилбарыг боловсруулан энэ оны 3 дугаар сарын 1-ний дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барихыг Шадар сайд М.Энхсайханд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД М.ЭНХСАЙХАН**

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Б.ЖАРГАЛСАЙХАН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2007 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр** | **Дугаар 29** | **Улаанбаатар хот**

### "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч" шагнал олгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Болзлын шаардлага хангаж, өндөр амжилт гаргасан Архангай аймгийн Ихтамир сумын Бугат багийн малчин Дорждангийн Тэгшжаргал, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 2 дугаар багийн малчин Шаухарбайн Нурдыхан, Баянхонгор аймгийн Баянлиг сумын 4 дүгээр багийн малчин Цэдэнгийн Шинэн, Булган аймгийн Дашинчилэн сумын Лах багийн малчин Гомбосүрэнгийн Зулбаян, Булган аймгийн Баян-Агт сумын Баянхайрхан багийн малчин Гонгорын Галсан, Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Баянбуурал багийн малчин Галдангийн Лхажив, Говь-Алтай аймгийн Дарви сумын Хужирт багийн малчин Осорхүүгийн Гансүх, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 3 дугаар багийн малчин Рэгжийбуугийн Очирбат, Дорнод аймгийн Баяндун сумын Нарэн багийн малчин Базарын Батмөнх, Дорнод аймгийн Хэрлэн сумын 5 дугаар багийн малчин Хэрээгийн Мөнхболд, Дундговь аймгийн Адаацаг сумын 5 дугаар багийн малчин Базарсүрэнгийн Баасанжав, Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 3 дугаар багийн малчин Данзанчүлтэмийн Өлзийбүрэн, Завхан аймгийн Сонгино сумын Тариат багийн малчин Цэдээгийн Ванган, Завхан аймгийн Сантмаргац сумын Баяндавс багийн малчин Арьхадын Бат-Эрдэнэ, Өвөрхангай аймгийн Баянгол сумын 1 дүгээр багийн малчин Самдангийн Жаргал, Өвөрхангай аймгийн Бүрд сумын 1 дүгээр багийн малчин Шатарын Чулуунхүү, Өмнөговь аймгийн Манлай сумын Жаргалант багийн малчин Бандийн Жаалхүү, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 8 дугаар багийн малчин Магсаржавын Хүрэлбаатар, Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5 дугаар багийн малчин Тогтохын Чотон, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 3 дугаар багийн малчин Лхагваагийн Базаррагчаа, Төв аймгийн Баянцагаан сумын 2 дугаар багийн малчин Алтангэрэлийн Сандагсүрэн,